

Монгол Улсын Их Сургуулийн захирлын 2014-2015 оны хичээлийн жилийн мэндчилгээ



Та бүхэндээ Монгол улсын хөгжил дэвшил, шинжлэх ухаан, эрдэм судлалын салбарыг тэргүүлсээр ирсэн Монгол Улсын Их Сургуулийн 2014-2015 оны хичээлийн шинэ жилийн баярын мэндийг хүргэе.

Манай сургууль түүхийнхээ бүхий л хугацаанд Монголын сор болсон эрдэмтэн мэргэдийн хичээл зүтгэлээр, эх орныхоо салбар бүрийг манлайлсан төгсөгчдийнхөө санаачилгаар хөгжин дэвшсээр ирсэн түүхтэй. Өнгөрсөн хичээлийн жилд манай МУИС дэлхийн шилдэг их, дээд сургуулийн жишигт нийцүүлэн бүтцийн томоохон өөрчлөлтийг хийлээ. Энэхүү өөрчлөлтийн үр дүнд МУИС-ийн оюутнууд өөрсдийн хүсэл сонирхол, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хичээлээ чөлөөтэй сонгон суралцах орчин нөхцлийг бүрдүүлэв. Өөрөөр хэлбэл уламжлалт сургалтын тогтолцооноос тодорхой хэмжээгээр татгалзаж, шинжлэх ухааны үндэстэй судалгаа шинжилгээ, техник технологийн ололт амжилтад суурилсан зах зээлийн эрэлт шаардлагыг хангахуйц сургалтын шинэ үүд хаалгыг нээж, орчин үеийн дэлхийн жишигтэй хөл нийлүүлэн алхаж байна.

МУИС-ийн шинэчлэлийн амин чухал асуудал болсон хичээлийн хөтөлбөрүүдийг дэлхийн тэргүүлэх их, дээд сургуулийн жишиг, монголынхоо уламжлалт сургах арга

барил, хуримтлуулсан өв санд тулгуурлан шинэчлэн боловсрууллаа. Энэ бүх өөрчлөлт шинэчлэлтийн төлөө хамтран ажилласан эрдэмтэн мэргэд, судлаач багш, ажилчид, оюутан залуустаа гүн талархал илэрхийлье.

Оюутан залуус та бүхэндээ чанартай, дэлхийн жишигт нийцсэн боловсрол олгох бүх талын нөхцөлийг бүрдүүлэхийн тулд шинэ E-номын санг барилгын ажлыг эхлүүлэн, судалгаа, шинжилгээний шинэ лаборатори байгуулж, судалгааны орчин нөхцлийг сайжруулахаар ажиллаж байна. Өнгөрсөн хичээлийн жилд МУИС-ийн санхүүгийн орчин сайжирч, хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдсэнийг дуулгахад таатай байна.

МУИС энэ хичээлийн жилд бүтцийн өөрчлөлт шинэчлэлийн ажлаа үргэлжлүүлэн оюутан хавсрага, хос мэргэжлээр сурах бололцоог нээлттэй болгож, хөтөлбөрүүдийг улам боловсронгуй болгохын зэрэгцээ магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдийг шинэчилж дуусгахаар төлөвлөж байна.

МУИС судалгаанд суурилсан дэлхийн нэр хүндтэй их сургууль болох зорилготой ажиллаж байгаагийн хувьд МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн дараагийн чухал асуудал бол профессор, багш нартаа олон улсын түвшинд чанартай судалгаа хийж, үр дүнгээ нийгэм, эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн болоод санхүүгийн таатай орчин бүрдүүлэхээр бэлтгэлээ базааж, эхний ээлжинд зарцуулах хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Энэ хичээлийн жил бид судалгааг тойрсон асуудлууд, судлаач багш, профессоруудыг дэмжихэд илүү анхаарал хандуулах болно.

Эрдэмтэн мэргэд, оюутан залуус, эцэг эхчүүд ээ,

Энэ хичээлийн жилд МУИС-д нийт 23,435 оюутан, магистрант, докторант суралцана. Шинээр 3,655 оюутан элслээ. Элсэгчдийн дундаж оноо 648 болсон нь өмнөх жилүүдээс даруй 36 оноогоор илүү байлаа. Монголын хамгийн шилдэг их сургуулийг сонгож, эх орныхоо өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн шинэ оюутан залуучууд Та бүхэндээ нийт багш ажилчдынхаа өмнөөс сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Та бүхнийг МУИС-ийн шинэчилсэн хөтөлбөрөөр амжилттай суралцаж, монгол орныхоо салбар бүрийг манлайлсан шилдэг боловсон хүчин болно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлье. Мөн МУИС-д үргэлжлүүлэн суралцаж байгаа оюутнууддаа ч сурлагын өндөр амжилт хүсье.

Эрдэм номын их үйл хэргийн төлөө энд хуран цугларч, шинэ хичээлийн жилийн нээлтэд оролцож байгаа та бүхэнд ажлын амжилт хүсье.

МУИС-ийн оюутан Монгол Улсын ирээдүйг бүтээнэ. Баярлалаа

МУИС-ийн захирал доктор А. Галтбаяр